

## ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын  
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.”, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор байгуулна.”, мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь хэсэг “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулах.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-д “Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх, түүнчлэн бие даасан, нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.”, Монгол Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор уг хороог байгуулна”, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-д “Түр хорооны бүрэлдэхүүнийг тогтоохдоо Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлэх боловч түр хорооны бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь цөөнхийн төлөөлөл байх, Улсын Их Хурал дахь нам, эвсэл бүрийн төлөөллийг оролцуулах зарчмыг баримтална.” гэж заасан байна.

Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хараат бус, бодитой, иж бүрэн мэдээлэлд тулгуурлах, ард түмний нийтлэг ашиг сонирхлыг дээдлэх, ил тод байх зарчимд үндэслэж хуулиар хязгаарласнаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл явц, холбогдох мэдээлэл, үр дүнг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй мэдээлэх хуультай.

Улсын Их Хурлын олонхыг бүрдүүлж буй улс төрийн хүчин хянан шалгах түр хорооны олонхыг бүрдүүлхийн зэрэгцээ түр хорооны даргыг олонхоос сонгож байгаа явдал нь түр хороо байгуулсан ач холбогдолыг бууруулж байна.

Түр хорооны даргыг сөрөг хүчнээс буюу цөөнхийн төлөөллөөс ажиллуулж чадвал хяналтын энэ чухал хэрэгслийг үр дүнтэй ашиглах нөхцөл бүрдэнэ.

**Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын хянан шалгах арга хэрэгсүүдийн нэг болох түр хороог илүү үр дүнтэй болгоход ач холбогдолтой гэж үзэж энэхүү хуулийн төслийг санаачилсан.**

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

---oOo---

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хараат бус, бодитой, иж бүрэн мэдээлэлд тулгуурлах, ард түмний нийтлэг ашиг сонирхлыг дээдлэх, ил тод байх зарчимд үндэслэж хуулиар хязгаарласнаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл явц, холбогдох мэдээлэл, үр дүнг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй мэдээлэх хуультай.

Олон улсын парламентын үйл ажиллагаанд “investigation hearing” буюу “мөрдөн шалгах нээлттэй сонсгол хийх” нь жишиг болсон арга хэлбэр. Энэ нь тухайн асуудалд холбогдох албан тушаалтан, гэрч, шинжээчийг Улсын Их Хурлаас дуудаж тайлбар, мэдүүлэг авах, тусгай шинжээч, хянан шалгагч томилох замаар нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тухайн тодорхой асуудлыг тал бүрээс нь шинжлэн судалж, бодит мэдээллийг ард түмэнд ил тод болгоход маш чухал ач холбогдолтой.

Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах, үнэлэх нээлттэй сонсголыг талуудын тэнцвэртэй төлөөллийг хангаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулах замаар иргэний мэдэх эрхийг бодитоор хангахаар хуульд тусгажээ.

Парламентат ёсны хувьд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тодорхой гурван чиг үүрэг байдаг нь хууль тогтоох, төлөөлөх, хянан шалгах. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд УИХ хууль тогтоох, төлөөлөх бүрэн эрхээ тодорхой түвшинд хэлбэржүүлэн тогтоосон. Гэвч хянан шалгах бүрэн эрхээ үр нөлөө багатай хэрэгжүүлж ирснийг судлаачид тэмдэглэсэн байдаг. Тиймээс Үндсэн хуульд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа эрх мэдлийн хяналт, тэнцлийг хангах зорилгоор УИХ-ын хянан шалгах бүрэн эрхийг шинэ шатанд гаргах зарчмын өөрчлөлт хийсэн. Уг өөрчлөлтийн дагуу УИХ-ын Хяналт шалгалтын тухай хуулийн төслийг нэг жилийн өмнө боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд өнгөрсөн оны арванхоёрдугаар сард баталсан билээ. УИХ хянан шалгах бүрэн эрхээ долоон арга хэлбэрээр хэрэгжүүлэхээр хуульд заасны нэг нь хянан шалгах түр хороо байгуулах юм.

Улсын Их Хурлын олонхыг бүрдүүлж буй улс төрийн хүчин хянан шалгах түр хорооны олонхыг бүрдүүлхийн зэрэгцээ түр хорооны даргыг олонхоос сонгож байгаа явдал нь түр хороо байгуулсан ач холбогдолыг бууруулж байна. Иймд түр хорооны даргыг сөрөг хүчнээс буюу цөөнхийн төлөөллөөс ажиллуулж чадвал хяналтын энэ чухал хэрэгслийг үр дүнтэй ашиглах нөхцөл бүрдэнэ.

Энэхүү хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд Түр хорооны даргыг түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар түр хорооны бүрэлдэхүүнд орсон цөөнхийн бүлгийн төлөөллөөс, хэрэв цөөнхийн бүлэг байхгүй бол цөөнхийн төлөөллөөс сонгохоор зохицуулсан.

**Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын хянан шалгах арга хэрэгсүүдийн нэг болох түр хороог илүү үр дүнтэй болгоход ач холбогдолтой.**

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**